



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 09 сарын 22 өдөр

Дугаар 459

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын  
худалдаагаар худалдах зөвшөөрөл  
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дархан-Уул аймгийн Газрын харилцаа, барилга, хот, байгуулалтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, нийт 28,536,755.50 (хорин найман сая таван зуун гучин зургаан мянга долоон зуун таван төгрөг тавин мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Дархан-Уул аймгийн Газрын харилцаа, барилга, хот, байгуулалтын газрын дарга Д.Ганбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Худалдсан автомашины улсын дугаарыг шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2020 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА   
Б. ЦЭНГЭЛ   
  
ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА   
Д. НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2020 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн  
459 дугаар тогтоолын хавсралт

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ  
АВТОМАШИН

Д/д	Автомашины нэр, марк, улсын дугаар, арал, хөдөлгүүрийн дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Нийт гүйлт (км)	Балансын нийт үнэ, хууримтлагдсан элэгдэл (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг )
1	Санта-фе, 05-48 ДАХ (арал-kmhsh81xdau609621)	2010/2010	328355	28,536,755.50	3,000,000.00
	Нийт дүн			28,536,755.50 (хорин найман сая таван зуун гучин зургаан мянга долоон зуун тавин таван төгрөг тавин мөнгө)	3,000,000.00 (гурван сая)